



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.06.20 № 24

Улсын Их Хурлын 2025 оны
53 дугаар тогтоолын хэрэгжилтийн
талаар

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос “Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.

Уг сонсголын хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 16 арга хэмжээ бүхий 53 дугаар тогтоолыг 2025 оны 6 дугаар сарын 05-ны өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Уг тогтоолын 11 дүгээр заалтад “агаар бохирдуулж байгаа аливаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөр, иргэн, аж ахуйн нэгжид төрөөс татаас, урамшуулал олгохгүй байх санхүүгийн механизмыг бүрдүүлэх, төсвийн хөрөнгөөр зуух, яндан, түлш зэрэг агаарын бохирдлын эх үүсвэрийг санхүүжүүлэхгүй байх, чанар, стандартын шаардлага хангасан утаагүй шахмал болон хийн түлшний үйлдвэрлэл, худалдааг хувийн хэвшлийн санаачилгад тулгуурлан зах зээлийн зарчимд нийцүүлэн зохион байгуулах” гэж тусгасан. Мөн уг тогтоолын 16 дугаарт “орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороог Ерөнхий сайд ахалж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг Улсын Их Хурлын хавар, намрын ээлжит чуулганы хугацаанд тогтмол тайлагнах, санхүүжилт, зарцуулалтын талаархи мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох” гэж заасан.

Гэтэл нийслэлийн өмчит “Тавантолгой Түлш” ХХК нь 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдөр “Хагас кокс буюу хөх нүүрсээр хийсэн шахмал түлш” худалдан авах тухай ТТТХХК/20250102556 дугаартай тендерийг Төсвийн ерөнхийлөн захирагч нь Нийслэлийн Засаг дарга байхаар зааж зарласан байна.

Түүнчлэн Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Үндэсний хорооны гишүүдэд чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоолын 5 дугаар заалтад “...Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах болон 2025-2026 оны галлагааны улиралд түлшээр тасралтгүй хангах зорилгоор импортын бэлэн түлшийг (хөх нүүрс) хэрэглэгчдэд зориулан жижиглэн савлах, агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэх ажлыг зохион байгуулах, шаардагдах зардлыг Засгийн газарт танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар), “Тавантолгой Түлш” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Амгалан) нарт...” гэсэн байна.

2025000031

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийг тус тус үндэслэн дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1.Төсвийн хөрөнгөөр гадаад улсаас “хөх нүүрсээр хийсэн шахмал түлш” худалдан авах тухай ТТТХХК/20250102556 дугаартай тендер нь Монгол Улсын Их Хурлын 53 дугаар тогтоолын 16 дугаар заалттай нийцэж байгаа эсэх;

2.Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 5 дахь заалт Монгол Улсын Их Хурлын 2025 оны 53 дугаар тогтоолтой нийцэж байгаа эсэх, нийцээгүй бол уг асуудлыг хэрхэн шийдвэрлэж, ямар арга хэмжээ авах талаар;

3.Монгол Улсын Их Хурлын 53 дугаар тогтоолын 16 дугаар заалтад нийцүүлэн Үндэсний хороог шинэчлэн зохион байгуулах талаар төлөвлөж байгаа эсэх.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.ЗОДЖАРГАЛ

2025000031